

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ

АХИСАН ТҮВШНИЙ СУРАЛЦАГЧДЫН ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ХУРААНГУЙ

Улаанбаатар, 2026

Ахисан түвшний суралцагчдын эрдэм шинжилгээний хурал

ЭМХЭТГЭЛИЙГ ЭРХЭЛСЭН:

ЭШИГ-ын мэргэжилтэн, доктор, Ж.Дуламсүрэн

МУБИС, Эрдэм шинжилгээ, инновацын албанаас эрхлэв.

Улаанбаатар, 2026 он

ГАРЧИГ

Байгалийн ухаан

- Detecting autumn bird migration through the south gobi region using acoustic monitoring
H.Маралгоо 2
- Монгол орны гардалавчтаны судалгаа, хамгаалалд Онон-Балжийн БЦГ яагаад чухал вэ?
Б.Дэлгэрмөрөн 2

Боловсрол судлал

- Түүхийн хичээлд дүрслэх (визуаль) эх сурвалж хэрэглэх боломж
Б.Дуламжав 4
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад багш нарын санаа зовнилыг судалсан үр дүнгээс
(Бага боловсролын математикийн туршилтын сургалтын хөтөлбөрийн жишээн дээр)
Ж.Дэнсмаа 4
- Хятад дахь ахмад настнуудын дижитал ур чадварын судалгааны халуун цэг, мэдлэгийн бүтэц ба хувьслын чиг хандлага: CNKI-д суурилсан citespace шинжилгээ
Meili Bao 5
- Бага боловсролын багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудын сэтгэл хөдлөлийн оюун ухааныг хөгжүүлэх арга зүйн туршилт судалгаа
Т.Норовсүрэн, А.Ичинхорлоо 6
- Антропологийн хандлага дахь их сургуулийн үндэстний оюутнуудын соёлын дасан зохицол ба сургалтын стратегийн судалгаа
Su Rige 7
- Угсрааны зургийн даалгавар гүйцэтгэлд аг технологийн нөлөөлөл ба оюутны орон зайн төсөөлөл чадварын хамаарал (ШУТИС-ийн Техникийн зурагзүй хичээлийн жишээн дээр)
У.Лхагвадорж, Э.Сүөд 7
- Энтрепренершип боловсролын судлагдсан байдлын тойм
Г.Батцэцэг 8
- Их сургуулийн англи хэлний хичээлд AIAS (хиймэл оюунд суурилсан үнэлгээний загвар)-ыг хэрэглэх нь: Их сургуулийн оюутнуудын бичих чадварыг сайжруулах туршилтын судалгаа
Harigui 9
- Сургуулийн өмнөх боловсролын багш нарын чанга уншлагын аргад хийсэн шинжилгээ (Дунд бүлгийн жишээн дээр)
М.Лхагвасүрэн 9
- Examining Student Engagement in Vocational English Classrooms: Evidence from Higher Vocational Colleges in Inner Mongolia, China
Wudanmuqier 10
- Сургалтын хэрэглэгдэхүүний судалгаа, зохион бүтээлт, туршилтын үр дүн
Б.Энхмандах 11

Өөрийн зохицуулалттай суралцахуйг дэмжих нь <i>Д.Аззаяа</i>	11
Проекц дүрслэлийн даалгавар гүйцэтгэхэд оюутанд үүсэж буй хүндрэл бэрхшээл, чанарын судалгааны үр дүн (ШУТИС-ийн техникийн зурагзүй хичээлийн жишээн дээр) <i>Д.Төгсжаргал, Э.Сувд</i>	12
Эмчилгээний тоног төхөөрөмжид техник үйлчилгээ хийх ур чадварыг үнэлсэн байдал /Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын техникч хөтөлбөрийн III дамжаа/ <i>Э.Энх-Үрэл</i>	12
ЕБС-ийн 5 дугаар ангийн англи хэлний сурах бичгийн соёлын агуулгын шинжилгээ <i>У.Дэлгэрсайхан</i>	13
Сурагчид "хиймэл оюун"-ыг хэрэглэж буй байдалд хийсэн шинжилгээ (Суурь боловсролын жишээн дээр) <i>Отгонбаяр Наранцаирал</i>	13
Монгол оюутнуудад хятад хэлээр бичих явцад тохиолдож буй түгээмэл бэрхшээлийг судалсан нь <i>Т.Энэбиш</i>	14
Химийн туршилтад суурилсан сургалтыг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудал <i>У.Нарантуяа, Б.Отгонжаргал</i>	15
Хос хэлний боловсролын онолын хүрээ: АХИС-г сургалтад хэрэгжүүлэх нь <i>Э.Оюунчимэг</i>	15
Монгол хөөмийн уламжлалт заах арга зүйн онцлог ба ганцаарчилсан сургалт <i>Е.Сачаогига, Э.Дүүриймаа</i>	16
Сагсан бөмбөгийн дасгалжуулагчийн манлайлал оюутан тамирчдын сэдэл ба багийн уур амьсгалд нөлөөлөх нь <i>С.Нуржан, Г.Өлзийсайхан</i>	16
Нийгэм, Хүмүүнлэг	
Чеховын «дугуйтай хүн» болон лу синьгийн «а кюгийн түүх»-ийг харьцуулан судлах <i>DaLaiMa</i>	18
“Эрдэнийн сан субашид”д тогтвортой байдлын цогц чадамж тусгагдсан байдалд хийсэн судалгааны дүн <i>Gegentana</i>	18
"Өнөөдөр"сонины эрүүл мэндийн мэдээллийн тулгамдсан асуудал , шийдвэрлэх арга зам <i>Байгаль</i>	19
Жангар хийгээд Калевалагын баатрын удам гарлын домог зүйн харьцуулал <i>Б.Тэргэл (Terigeli)</i>	19
“XX зууны дунд үеийн эрэгтэй яруу найрагчдын бүтээл дэх эм хүйсийн дүрслэлийн мэдрэмж” (Хайрын шүлгийн жишээн дээр) <i>М.Чинхүсэл</i>	20

"Ам" хэмээх концептын зүйрлэл ба төлөөллийн утгыг шинжлэх нь (Ч.Лодойдамбын
Тунгалаг тамир" романы жишээн дээр)
Ч.Цэрэнсугар

Өмнийн говиор дамжин өнгөрөх намрын нүүдлийн шувуудыг акустик ашиглан илрүүлэх нь

Н.Маралгоо

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Математик, Байгалийн ухааны сургууль, Биологийн тэнхим
maralgoomarlaa1@gmail.com

Хураангуй. Говийн бүс нутаг нь Төв Азийн нүүдлийн шувуудын чухал дамжин өнгөрөх нутаг юм. Сүүлийн жилүүдэд энэ бүс нутагт шувуудын экологи, ялангуяа хүний үйл ажиллагааны нөлөөллийг судлах ажил нэмэгдэж байгаа ч тэдгээрийн улирлаас шалтгаалсан нүүдлийн зүйлүүдийн бүрдэл, өдрийн болон шөнийн идэвхийг судалсан ажил хомс байна. Дэлхийн олон улсад био-акустик буюу пассив акустик мониторинг (РАМ) нь экологийн судалгаанд өргөн хэрэглэгдэх болсон бөгөөд амьтдын дуу авиагаар дамжуулан тэдний тархалт, нүүдэл, популяцийн үзүүлэлтүүдийг үнэлэх боломжтой харуулах болсон. Бид Монголд анх удаа шувуудын нүүдлийг тэдний дуу авиагаар нь судлах боломжтой эсэхийг энэ судалгаагаар үнэлэв. Судалгааг Өмнийн говиор шувууд нүүдлийн үедээ түр саатан амардаг хайлаас бүхий 30 амьдрах орчныг сонгож акустик төхөөрөмж буюу дуу хураагуур байршуулсан юм. Төхөөрөмжөө 32 кГц давтамж, 18 dB өсгөлттэй, WAV форматаар 6-10 сарын хугацаанд өглөө болон орой бичлэг хийсэн. Судалгааны эхний өгөгдөл буюу 2025 оны 8-10 дугаар саруудад цуглуулсан дуун өгөгдөлд дүн шинжилгээ хийж үзэхэд өмнийн говиор дамжин өнгөрөх шувуудын намрын нүүдлийн оргил үе нь 9 дүгээр сард илэрч, өглөө 6 цаг болон оройн 18 цагуудад хамгийн идэвхтэй байдгийг тогтоов. Судалгаанд нийт 270 зүйлийн шувуу бүртгэгдсэн бөгөөд үүнээс 179 зүйл нь нүүдлийн харин 91 зүйл нь суурин болон урт хугацаанд нүүдэллэдэг шувуудад хамаарч байна. Бидний судалгааны үр дүнгээс харахад намрын улиралд говийн бүсэд шувуудын олон янз байдал өндөр байгааг илэрхийлэхийн зэрэгцээ тухайн бүс нутаг нь нүүдлийн шувуудын түр саатах, амрах, энерги нөхөхөд чухал нөлөө үзүүлэх орчин болж байна. Мөн акустик төхөөрөмжийг судалгаанд хэрэглэх нь хүний оролцоо шаардахгүй, удаан хугацаанд тасралтгүй бичлэг хийх гээд маш том давуу талуудтайг бидний судалгаа харуулж байна.

Түлхүүр үг: Пассив акустик мониторинг, нүүдлийн шувууд, зүйлийн баялаг, улирлын идэвх, түр зогсолт

Удирдсан: Г.Онолрагчаа, МУБИС, доктор Б.Батбаяр, WCS

Монгол орны гар далавчтаны судалгаа, хамгаалалд Онон-Балжийн БЦГ яагаад чухал вэ?

Б.Дэлгэрмөрөн

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Математик,
Байгалийн ухааны сургууль, Биологийн тэнхим
email: b.delgermuren@gmail.com

Хураангуй. Монгол улсын нийт газар нутгийн 20.8% нь Улсын ТХГН-ийн сүлжээнд хамаардаг. Харин гардалавчтан нь тухайн бүлгэмдлийнхээ олон янз байдлыг илтгэдэг, экологийн индикатор бөгөөд

мониторинг судалгаа хийхэд тохиромжтой зүйл тул тусгай хамгаалалттай газар нутгийн хамгааллын менежментэд чухал ач холбогдолтой бөгөөд нийт гардалавчтаны зүйлүүд элбэг тархсан байдаг Онон-Балжийн БЦГ-ын гардалавчтаны зүйлийн баялгийг тодорхойлж, урт хугацааны мониторинг судалгаа хийх боломжийг тандах нь энэхүү судалгааны ажлын үндэслэл юм. Бидний судалгаа нь Онон-Балжийн БЦГ-н гардалавчтаны зүйлийн баялгийг тодорхойлж цаашдын мониторинг судалгааны суурь мэдээллийг бүрдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг илэрхийлэгч индикатор зүйлийг тогтоох зорилготой юм. Судалгааг гүйцэтгэсэн Онон-Балжийн БЦГ нь байгалийн мужийн төлөөллийн хувьд Хэнтийн уулт өндөрлөгийн зүүн хэсгийн ойт хээр, умард хуурай хээрийн дэд мужийн ой, нугат хээр, нуга бүхий ойт хээрийн район, Онон-Улзын сав газрын нам уул, хотгор бүхий хээр, хуурай хээрийн мужийн нуга, нарс бүхий хээрийн районуудыг тус тус төлөөлөн оршдог. Бид Онон-Балжийн БЦГ-т гардалавчтаны олон янз байдлын судалгааг 20 цэгт 6 дугаар сарын 25-аас 14 хоног, 8 дугаар сарын 1-нээс 10 хоног тус тус хээрээр хийж гүйцэтгэлээ. Судалгааг ой, ойт хээр, нуга, татмын ой, намаг, голын сайр, агуй, суурин газар зэрэг ялгаатай орчинд хийсэн. Гардалавчтаны судалгаанд Collins 2016, Ариунболд 2018 нарын аргазүйг хэрэглэсэн. Баригдсан гардалавчтануудад MNGXXXXX сериал дугаар бүхий бөгж зүүж буцаан сулласан. Бид судалгаандаа Онон-Балжийн БЦГ-т 1992, 2008, 2010, 2014 онуудад хийгдсэн судалгааны материал болон 2025 оны зун болон өвлийн судалгааны үр дүнг оруулсан. Бид энэхүү судалгаагаар гардалавчтаны 8 зүйлийн 64 бодгалийг барьж, 54-т бөгж зүүн буцаан сулласан бөгөөд хээрийн багваахай (*Myotis davidii*) анх удаа Онон-Балж БЦГ-аас баригдав.

Хэнтий аймгийн Баян-Адарга сумын нутагт орших Буурлын агуйд зуны улиралд бор соотгойн 3 бодгаль, Дадал сумын нутагт орших Сөөгтийн агуйд өвлийн улиралд бор соотгойн 4 бодгаль орогнон, ичээллэж байсан. Тус хоёр агуйд цаг уур хэмжигч төхөөрөмж болон автомат камер суурилуулсан. Онон-Балжийн сав газраас дөрвөн төрөлд хамаарах 10 зүйлийн гардалавчтанг тэмдэглэлээ. Үүнд: *Myotis* төрөлд 6 зүйл, *Vespertilio*, *Plecotus*, *Cnephaeus*, *Murina* төрлүүд тус бүр нэг зүйлийг бүртгэлээ. Энэ нь Монгол орны гардалавчтаны зүйлүүдийн 50 хувийг эзэлнэ.

Эдгээр гардалавчтанууд нь дэлхийн байгаль хамгаалах холбооны (IUCN) үнэлгээгээр олон улсад анхааралд өртөхөөргүй 9, ховордож болзошгүй 1, бүс нутгийн хувьд анхааралд өртөхөөргүй 6, мэдээлэл дутмаг 2, ховордож болзошгүй 1, эмзэг 1 зүйл байна.

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт орших Сөөгтийн агуйд бор соотгой (*Plecotus ognevi*), умрын сарсаахай (*Cnephaeus nilssonii*) ичээллэж, Баян-Адарга сумын нутагт орших Буурлын агуйд зуны улиралд бор соотгой байршдаг буюу тус УТХГ нь гардалавчтаны ичээлэх, орогнох чухал цэг юм.

Түлхүүр үг: Гардалавчтан, Онон-Балж БЦГ, зүйлийн олон янз байдал, мониторинг судалгаа
Удирдсан: Ж.Ариунболд, МУБИС

Түүхийн хичээлд дүрслэх (визуаль) эх сурвалж хэрэглэх боломж

Б.Дуламжав

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,
Боловсрол судлалын тэнхим
bayandelgerdulamjav@gmail.com

Хураангуй. Сүүлийн жилүүдэд боловсролын салбарт шавь төвт, идэвхтэй суралцах арга зүйг төлөвшүүлэх, сургалтын агуулга, арга хэлбэрийг орчин үеийн нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлэх асуудал онцгой ач холбогдолтой болж байна. Ялангуяа түүхийн хичээлийн хувьд сурагчдын өнгөрсөн үйл явцыг бодитойгоор төсөөлөх, шалтгаан үр дагаврын холбоог ойлгох, нэгтгэн дүгнэх, үнэлэх чадварыг хөгжүүлэхэд сургалтын хэрэглэгдэхүүн, эх сурвалжийн сонголт, тэдгээрийг ашиглах арга зүй чухал нөлөө үзүүлдэг. Түүхийн сургалтад уламжлалт бичгийн сурвалжийг давамгайлан хэрэглэж ирсэн хэдий ч орчин үеийн боловсролын онол, практикт дүрслэх (визуаль) эх сурвалжийг сургалтад үр дүнтэй ашиглах боломж, хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Зураг, гэрэл зураг, зурагт хуудас, газрын зураг, бүдүүвч, инфографик, кино, баримтат бичлэг зэрэг дүрслэх эх сурвалж нь сурагчдын анхаарлыг татах, ойлголтыг тодорхой болгох, мэдээллийг цогцоор нь хүлээн авах, ой тогтоолтыг сайжруулах давуу талтай. Гэвч ерөнхий боловсролын сургуулийн түүхийн хичээлд дүрслэх эх сурвалжийг оновчтой ашиглах арга зүй төдийлөн боловсронгуй бус, дүрслэх эх сурвалжийн хэрэглээ жигд бус, ялгаатай түвшинд байгаа нь судалгааны явцад харагдсан бөгөөд энэ нь дүрслэх эх сурвалжийг сургалтын зорилттой уялдуулан системтэй хэрэглэх арга зүйг цогцоор нь боловсруулах шаардлагатайг харуулж байна. Иймээс дээрх асуудлын хүрээнд дүрслэх эх сурвалжийг хэрэглэх онол, арга зүйн үндэс, боловсрол дахь практик хэрэглээ, тэдгээрийн танин мэдэхүйн үр өгөөжийг судлан, шинжлэх шаардлагатай байна.

Түлхүүр үг: Дүрслэх эх сурвалж, түүхийн хичээл, хичээлийн хэрэглэгдэхүүн, бүтээлч үйл ажиллагаа
Удирдсан: Х.Баярмаа, МУБИС

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад багш нарын санаа зовнилыг судалсан үр дүнгээс

(Бага боловсролын математикийн туршилтын сургалтын хөтөлбөрийн жишээн дээр)

Ж.Дэнсмаа

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,
Боловсрол судлалын тэнхим
densmaa@mier.mn

Хураангуй. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудал нь 1970-1980-аад оноос эхлэн боловсрол судлалын бие даасан чиглэл болон хөгжиж байна. Fullan ба Pomfret (1977) нар сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг зөвхөн суралцагчийн сурлагын амжилтаар хэмжих нь хангалтгүй бөгөөд хэрэгжилтийг бие даасан үйл явц болгон судлах шаардлагатай гэж үзсэн байдаг. Олон судалгаанд боловсролын шинэчлэл амжилттай хэрэгжих эсэх нь боловсруулсан хөтөлбөрөөс илүүтэй “хэрэгжүүлэгч”-ийн бэлэн байдал, ойлголт, үйл ажиллагаанаас хамаардаг болохыг тогтоосон. Манай улсад ч сургалтын хөтөлбөрийг турших, хэрэгжилтийн явцад үнэлэх, сайжруулах бодлогын шаардлага нэмэгдэж, хөтөлбөрийн хэрэгжилтийг урт хугацаанд тасралтгүй судлах хэрэгцээ үүссэн. Бид сургалтын

хөтөлбөрийн хэрэгжилтийг ихэвчлэн суралцагчдын сурлагын амжилтаар дамжуулан дүгнэх хандлага давамгайлж, хэрэгжилтийг бодитоор тодорхойлох, “хэрэгжүүлэгч”-д тулгамдсан асуудлыг судлах арга зүйн үндэслэл хангалтгүй хэвээр байна. Иймээс сургалтын хөтөлбөрийг анги, танхимд бодитоор хэрэгжүүлэх үйл явцад багшид тулгарч буй асуудал, тэдний хандлага, хэрэглээний түвшнийг судлах нь чухал байна. 2024-2025 оны хичээлийн жилд бага боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, турших явцад туршигч багш нарын ойлголт, бэлэн байдал, тулгамдсан асуудлыг бодитой тодорхойлох шаардлага гарч ирсэн. Энэхүү судалгаагаар бага боловсролын математикийн туршилтын сургалтын хөтөлбөр, суралцагчийн гарын авлага, дасгал ажлын дэвтрийг анги, танхимд хэрэгжүүлэх явцад багшийн санаа зовнисон асуудлыг СВАМ загвар ашиглан тодорхойлох зорилго тавьсан. Concerns-Based Adoption Model (CВАМ) нь боловсролын инновац, шинэ хөтөлбөрийн хэрэгжилтийг судлахад өргөн хэрэглэгддэг онолын загвар бөгөөд багшийн санаа зовнил (Stages of Concern)-ыг хэмжих үзүүлэлтээр хэрэгжилтийг тодорхойлох боломж олгодог. Судалгаанд бага боловсролын математикийн сургалтын шинэчилсэн хөтөлбөрийн туршигч нийслэлийн, аймгийн төвийн, сумын төвийн тус бүр нэг, нийт гурван сургуулийн 15 багшийг хамруулсан. Энэ удаа туршилтын эхэн болон төгсгөлд, нийт 2 удаагийн асуулга (SoCQ)-ын үр дүнг танилцуулж байна. Судалгааны үр дүнд багш нарын ихэнх нь “өөрийн” шатанд санаа зовнил ихтэй байна. Харин “ажил үүргийн” болон “үр нөлөөний” шатанд санаа зовнил багатай байна. Өөрөөр хэлбэл, туршилтын явцад багш нар сургалтын хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлэх, туршилтыг гүйцэтгэснээр өөрийнх нь мэргэжлийн хөгжилд ямар нөлөөтэй талаар илүү их мэдээлэл хүсэж байгаагаар илэрхийлсэн бол өөрийн хэрэглээ нь суралцагчийн хөгжилд ямар нөлөө үзүүлэх талаар огт санаа зовнихгүй байна. Мөн багш нар “хамтын ажиллагаа” шатанд өндөр оноо авсан нь тэдний хамтын ажиллагааг дэмжсэн үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатайг харуулж байна.

Түлхүүр үг: Сургалтын хөтөлбөр, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, багш, санаа зовнил, санаа зовнилын үе шат, санаа зовнилд суурилсан шийдвэр гаргах загвар

Удирдсан: М.Итгэл, МУИС

Хятад дахь ахмад настнуудын дижитал ур чадварын судалгааны халуун цэг, мэдлэгийн бүтэц ба хувьслын чиг хандлага: CNKI-д суурилсан Citespace шинжилгээ

Bao Meili

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,
Боловсрол судлалын тэнхим

baomeili86@163.com

Хураангуй. Хүн амын хөгшрөлт болон дижитал шилжилт эрчимжихийн хэрээр ахмад настнуудын дижитал ур чадвар нь цахим үйлчилгээ авах, нийгмийн оролцоогоо хадгалах, ухаалаг асаргаа болон идэвхтэй хөгшрөлтийг хэрэгжүүлэхэд чухал хүчин зүйл болж байна. Хятадад дижитал үйлчилгээ өргөжихийн зэрэгцээ ахмад настнуудын технологид нэвтрэх, ашиглах, ойлгох чадварын ялгаа улам тодорч байгаа тул энэ чиглэлийн судалгааны ерөнхий бүтэц, гол сэдэв, хөгжлийн чиг хандлагыг системтэй тодруулах шаардлагатай байна. Судалгаанд CNKI мэдээллийн санг үндсэн эх сурвалж болгон ашиглаж, 2014-2025 оны хооронд “ахмад настан/өндөр настан” болон “дижитал ур чадвар/дижитал боловсрол/дижитал чадамж” зэрэг сэдвээр нийтлэгдсэн бүтээлүүдийг хайсан. Давхардсан болон сэдэвт шууд хамааралгүй материалыг хассаны дараа 466 өгүүллийг эцсийн шинжилгээнд хамруулсан. Өгөгдлийг CiteSpace 7.0 программаар боловсруулж, түлхүүр үгийн хам илрэл, кластер, цаг хугацааны шугам, гэнэтийн илрэлт, зуучлалын төвлөрөл болон Sigma үзүүлэлтээр мэдлэгийн зураглалын шинжилгээ хийсэн. Шинжилгээний үр дүнгээс харахад Хятад дахь ахмад настнуудын дижитал ур чадварын судалгаа 2021 оноос хойш эрчимтэй нэмэгдсэн байна. Түлхүүр үгийн

кластер шинжилгээгээр 15 үндсэн кластер илэрч, $Q=0.6128$, $S=0.9183$ гарсан нь кластерийн бүтэц тодорхой, үр дүн найдвартай болохыг харуулж байна. Судалгааны гол сэдвүүд нь дижитал боловсрол, дижитал ялгаа, дижитал хамруулалт, дижитал оролцоо, дижитал “буцаан дэмжлэг”, ухаалаг настайчуудын асаргаа, ахмад настанд ээлтэй зохицуулалт, өндөр насны эдийн засаг зэрэг чиглэлд төвлөрчээ. “Дижитал боловсрол” нь хамгийн өндөр давтамжтай бөгөөд гол холбогч ойлголт болж, харин “дижитал буцаан дэмжлэг” нь сүүлийн жилүүдийн шинэ тэргүүлэх чиглэл болж байна. Хятад дахь ахмад настнуудын дижитал ур чадварын судалгаа нь эхэн үеийн “дижитал ялгааг тодорхойлох” хандлагаас аажмаар “чадавх бүрдүүлэлт-харилцааны дэмжлэг-хэрэглээний орчин-хөгжлийн боломж” гэсэн илүү цогц чиглэл рүү шилжиж байна. Цаашид ахмад настнуудын дижитал ур чадварын хэмжилтийг нарийвчлах, дижитал “буцаан дэмжлэг”-ийн механизмыг гүнзгийрүүлэх, ухаалаг асаргаа, ахмад настанд ээлтэй технологи, өндөр насны эдийн засагтай холбосон судалгааг өргөжүүлэх шаардлагатай.

Түлхүүр үг: Ахмад настнууд, дижитал ур чадвар, дижитал боловсрол, дижитал хамруулалт, CiteSpace, CNKI

Удирдсан: Чү.Байгальмаа, Б.Жавзандулам, МУБИС

Бага боловсролын багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудын сэтгэл хөдлөлийн оюун ухааныг хөгжүүлэх арга зүйн туршилт судалгаа

Т.Норовсүрэн, А.Ичинхорлоо

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Архангай аймаг дахь салбар сургууль, Боловсрол судлалын тэнхим
norovsuren@msue.edu.mn

Хураангуй. Энэхүү судалгааны зорилго нь бага боловсролын багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудын сэтгэл хөдлөлийн оюун ухааныг (EQ) хөгжүүлэхэд чиглэсэн дасгалд суурилсан арга зүйн үр нөлөөг туршилтаар тодорхойлоход оршино. Судалгаанд МУБИС-ийн Архангай аймаг дахь салбар сургуулийн бага боловсролын багш мэргэжлийн 2-р курсийн 42 оюутан хамрагдаж, 2026 оны 02 дугаар сарын 06-наас 03 дугаар сарын 27-ны хугацаанд туршилтын өмнөх, туршилтын дараах загвар, өөрчлөлтөөр судалгаа явуулав. EQ-ийн түвшинг Даниал Големаны загвар болон К.В. Петридесийн боловсруулсан TEIQue аргачлалд тулгуурласан асуулгаар хэмжиж, өгөгдлийг SPSS программ ашиглан paired samples t-test шинжилгээгээр боловсруулсан. Судалгааны хэрэглэгдэхүүний найдвартай байдлын коэффициент Cronbach's Alpha = .704 гарсан нь хэмжүүр хангалттай найдвартай болохыг харуулсан. Туршилтын үр дүнд EQ-ийн бүх үзүүлэлт статистикийн ач холбогдолтой өссөн ($p < .001$) бөгөөд өөрийгөө ухамсарлах +1.052, өөрийгөө зохицуулах +1.300, сэдэл +1.193, эмпати +0.979, нийгмийн ур чадвар +1.193 нэгжээр тус тус нэмэгдсэн байна. Ялангуяа өөрийгөө зохицуулах чадвар хамгийн өндөр өсөлттэй гарсан нь хэрэгжүүлсэн арга зүйн үр нөлөөг илтгэж байна. Чанарын ажиглалтаар сургалтын эхэнд давамгайлж байсан гуниг, стресс, бухимдал зэрэг сөрөг сэтгэл хөдлөлийн илрэл буурч, оролцогчдын өөрийгөө ойлгох, бусдыг сонсох, харилцаанд идэвхтэй оролцох чадвар сайжирсан байна. Иймээс 8 долоо хоногийн хугацаанд хэрэгжүүлсэн дасгалд суурилсан EQ хөгжүүлэх арга зүй нь бага боловсролын багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудын сэтгэл хөдлөлийн оюун ухааныг хөгжүүлэхэд үр дүнтэй болох нь статистикийн болон практик үр дүнгээр батлагдлаа.

Түлхүүр үг: Сэтгэл хөдлөлийн оюун ухаан, EQ, эмпати, өөрийгөө зохицуулах, багш боловсрол

Антропологийн хандлага дахь их сургуулийн үндэстний оюутнуудын соёлын дасан зохицол ба сургалтын стратегийн судалгаа

Su Rige

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Боловсрол судлалын тэнхим
407760400@qq.com

Хураангуй: Даяаршил эрчимжиж, олон соёл нэвтрэн орж ирэхийн хэрээр манай улсын их, дээд сургуулиудад үндэстний оюутнуудын тоо улам бүр нэмэгдэж байна. Үндэстний оюутнуудын соёлын дасан зохицлын асуудал нь их сургуулиудын анхаарлын төвд орж буй чухал сэдэв болж байна. Соёлын дасан зохицол нь оюутны хувь хүний хөгжил, төлөвшил, мөн их сургуулийн сургалтын шинэчлэл, үндэстний эв нэгдэл, дэвшлийн үйл хэрэгт чухал ач холбогдолтой. Энэхүү өгүүлэл нь антропологийн үүднээс, соёлын дасан зохицлын онолыг баримтлан, их сургуулийн үндэстний оюутнуудын хэл, сургалт-заах арга, амьдралын хэв маяг зэрэг талууд дахь дасан зохицлын асуудлыг шинжилж, тэдний тулгарч буй бэрхшээлээс үүдэн хөтөлбөр, сургалтын агуулга, их сургуулийн соёлын орчин зэрэг талаас сургалтын зөвлөмж дэвшүүлж, үндэстний оюутнуудыг их сургуулийн амьдралд илүү сайн дасан зохицоход дэмжлэг үзүүлэх, олон соёлын зохицон орших нөхцөлийг бүрдүүлэхэд онолын үндэс болохыг зорилоо.

Түлхүүр үг: хиймэл оюун ухааны боловсрол; зүйр цэцэн үгийн уламжлал; боловсролын ёс зүй; өгөгдлийн нууцлал; алгоритмын хазайлт; соёлын түгээлт

Удирдагч: Г.Цогзолмаа, МУБИС

Угсрааны зургийн даалгавар гүйцэтгэлд аг технологийн нөлөөлөл ба оюутны орон зайн төсөөлөх чадварын хамаарал

(ШУТИС-ийн Техникийн зурагзүй хичээлийн жишээн дээр)

У.Лхагвадорж, Э.Сувд

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Барилга Архитектурын сургууль,
Инженерийн зурагзүйн тэнхим

u.lkhagvadorj@must.edu.mn

Хураангуй. Энэхүү судалгаа нь өргөтгөсөн бодит байдлын (AR) технологийг инженерийн зурагзүйн сургалтад ашиглах нь оюутны нэгж угсрааны зургийн даалгавар гүйцэтгэлд үзүүлэх нөлөөллийг туршилтаар шалгасан. Судлаачдыг сонгон суралцаж буй оюутнуудыг угсрааны зургийн даалгавар гүйцэтгэхдээ AR апп ашиглах туршилтын бүлэг, угсрааны зургийг биет дүрслэлээр салгаж дүрсэлсэн зураг ашиглах хяналтын бүлэгт хуваан сургалтыг тус улирлын IX-XV долоо хоногийн турш зохион байгуулав. Оюутны орон зайн төсөөлөх чадварыг PSVT тестээр туршилтын өмнө шалгаж, сургалтын дараа угсрааны зургийн даалгавар гүйцэтгүүлж, SPSS-26 статистикийн программ хангамж ашиглан өгөгдлийг шинжлэв. Судалгаанд AR ашигласан туршилтын бүлэг болон хэвлэмэл зураг ашигласан хяналтын бүлгийг харьцуулсан бөгөөд сургалтын өмнө хоёр бүлгийн суурь түвшин ижил байсан. Харин сургалтын дараа туршилтын бүлэг бүх даалгаврын үзүүлэлтээр хяналтын бүлгээс статистикийн хувьд ач холбогдолтой өндөр гүйцэтгэл үзүүлсэн нь AR технологи нь 3D дүрслэлийг илүү ойлгомжтой болгож, угсрааны бүтцийг төсөөлөх чадварыг сайжруулж байгааг харуулсан. Мөн орон зайн төсөөлөх чадвар болон угсрааны зургийн гүйцэтгэлийн хооронд $r = 0.501$ ($p < 0.01$) гэсэн дундаас дээш эерэг

хамаарал илэрсэн. Энэхүү судалгаанд AR технологийг сургалтад ашиглах нь оюутны нэгж угсрааны зургийн даалгавар гүйцэтгэх чадварт хэрхэн нөлөөлж буйг туршилтаар шалгасан бөгөөд сургалтаас өмнөх үр дүнгээр AR ашигласан туршилтын бүлэг болон хэвлэмэл зураг ашигласан хяналтын бүлгийн хооронд орон зайн төсөөлөх чадварын хувьд статистикийн ач холбогдолтой ялгаа илрээгүй нь хоёр бүлгийн анхны түвшин ижил байсныг харуулсан. Харин сургалтын дараах үнэлгээнд модель босгох, эд анги угсрах болон угсрааны ажлын зураг гүйцэтгэх гэсэн бүхий л үзүүлэлтээр туршилтын бүлэг хяналтын бүлгээс статистикийн хувьд ач холбогдолтой өндөр гүйцэтгэл үзүүлсэн тул AR технологи нь 3 хэмжээст дүрслэлийг илүү ойлгомжтой, бодитой болгож, эд ангийн геометр бүтэц болон харилцан байрлалыг төсөөлөх чадварыг дэмжиж байгааг илтгэнэ.

Түлхүүр үг: AR технологи, инженерийн зураг, угсрааны зураг, орон зайн төсөөлөл, 3 хэмжээст дүрслэл, сургалтын технологи, корреляцийн шинжилгээ

Энтрепренершип боловсролын судлагдсан байдлын тойм

Г.Батцэцэг

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Боловсрол судлалын сургууль, Боловсрол судлалын тэнхим,
gbattsetseg08@gmail.com

Хураангуй. Энтрепренершип боловсрол нь дээд боловсролын байгууллагуудад инновац, эдийн засгийн хөгжил, хүний капиталын өсөлтийг дэмжих чухал механизм болж байна. Энэхүү судалгааны тойм нь олон улсын эрдэм шинжилгээний бүтээлүүдэд тулгуурлан энтрепренершип боловсролын онолын үндэс, үр нөлөө, сургалтын арга зүй болон олон улсын хөгжлийн ялгааг нэгтгэн авч үзсэн болно. Онолын хувьд энтрепренершип боловсролыг төлөвлөсөн зан үйлийн онол, туршлагаар суралцах онол, хүний капиталын онол, экосистемийн хандлага болон сэтгэлзүйн онолын хүрээнд тайлбарладаг. Эдгээр нь хамтдаа энтрепренершип боловсрол нь хувь хүний хандлага, ур чадвар, сэдэл болон институцийн орчны харилцан үйлчлэл дээр суурилдаг болохыг харуулж байна. Эмпирик судалгаанууд энтрепренершип боловсрол нь оюутнуудын мэдлэг, ур чадвар, хандлагад хүчтэй эерэг нөлөөтэй боловч бодит бизнес эхлүүлэх зан үйлд үзүүлэх нөлөө харьцангуй сул, шууд бус болохыг тогтоосон байна. Энэ нь боловсролын нөлөө ихэвчлэн танин мэдэхүйн болон хандлагын түвшинд илэрч, зан үйлийн түвшинд хүрэхдээ институцийн болон экосистемийн хүчин зүйлсээс ихээхэн хамаардаг болохыг харуулна. Сургалтын арга зүйн хувьд туршлага дээр суурилсан, venture creation чиглэлийн сургалт нь уламжлалт лекцэд суурилсан сургалтаас илүү үр дүнтэй болохыг олон судалгаанд батлагдсан. Мөн улс орнуудын хувьд энтрепренершип боловсролын хөгжил нь АНУ-д зах зээлд суурилсан, Европт академик чиглэлтэй, Азид төрийн бодлоготой уялдан экосистемийн хэлбэрээр хөгжиж байна. Нийт дүгнэлтээр энтрепренершип боловсрол нь зөвхөн сургалтын хөтөлбөр бус, харин микро (хувь хүн), мезо (их сургууль), макро (үндэсний экосистем) түвшний уялдаа бүхий системийн шинжтэй үзэгдэл юм.

Түлхүүр үг: Энтрепренершип боловсрол, Онолын хүрээ, Сургалтын арга зүй, Олон улсын харьцуулалт, Институцийн орчин, Үр нөлөөний түвшин

**Хиймэл оюунд суурилсан “AIAS” загварыг англи хэлний хичээлд хэрэглэх нь:
бичих чадварыг хөгжүүлэх туршилтын судалгаа
(БНХАУ-ын ӨМӨЗО-ны Жинийн Их Сургуулийн жишээн дээр)**

Harigui

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,
Боловсрол судлалын тэнхим
harigui95@gmail.com

Хураангуй. Энэхүү судалгаанд хиймэл оюунд суурилсан AIAS (AI-based Assessment System) загварыг англи хэлний сургалтад хэрэгжүүлж, суралцагчдын бичих чадварт үзүүлэх нөлөөг туршилтын аргаар судалсан. Судалгаанд нийт 100 оюутан хамрагдсан бөгөөд туршилтын болон хяналтын бүлэгт хуваан судалсан. AIAS загварыг онолын хувьд бүтээлч сургалтын онол (Jean Piaget, 1970; Lev Vygotsky, 1978), буцаан холбооны онол (John Hattie & Helen Timperley, 2007) болон танин мэдэхүйн ачааллын онол (John Sweller, 1988)-д тулгуурлан хэрэгжүүлсэн. Энэхүү судалгаанд AIAS загварыг туршилтын бүлэгт ашиглаж, суралцагчдын бичих чадварыг хөгжүүлэх зорилгоор автомат үнэлгээ, шуурхай буцаан холбоо болон давтамжтай засварлах үйл явцыг дэмжсэн. Судалгааны үр дүнгээс харахад AIAS загварыг ашигласан сургалт нь суралцагчдын бичих чадварт статистикийн хувьд ач холбогдолтой эерэг нөлөө үзүүлсэн ($p < 0.05$). Мөн асуулгын судалгаагаар суралцагчид AIAS системд эерэг хандлагатай (Mean > 3.0) бөгөөд Cronbach's Alpha = 0.936 гарсан нь судалгааны хэмжүүр өндөр найдвартай болохыг харуулж байна. Иймээс хиймэл оюунд суурилсан AIAS загвар нь англи хэлний бичих чадварыг хөгжүүлэхэд онолын болон практикийн хувьд үр дүнтэй арга болох нь энэхүү судалгаагаар батлагдаж байна.

Түлхүүр үг: хиймэл оюун, AIAS загвар, англи хэлний сургалт, бичих чадвар, буцаан холбоо
Удирдсан: О.Мягмарсүрэн, МУБИС

**Сургуулийн өмнөх боловсролын багш нарын чанга уншлагын аргад хийсэн шинжилгээ
(Дунд бүлгийн жишээн дээр)**

М.Лхагвасүрэн

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол Судлалын Сургууль,
Боловсрол Судлалын Тэнхим
melmo.else@gmail.com

Хураангуй. 2023 оны судалгаагаар 6 настай суралцагчийн сургуульд бэлтгэгдсэн байдал 72.3%, ерөнхий боловсролын 2 дугаар ангийн суралцагчийн унших чадвар 41.4% (Боловсролын яам, 2024в). Эндээс харахад Монгол хүүхдийн унших ойлгох чадварыг багаас нь анхаарч, тогтмол ном уншиж өгөхөөс гадна бага насны хүүхдийг номтой нөхөрлүүлэх шаардлага бий болоод байна. Гэтэл нийт эцэг эхчүүдийн ердөө 9.7% нь бага насны хүүхдэдээ өдөр бүр ном уншиж өгдөг гэсэн байна (Азийн хөгжлийн сан, 2022). Харин энэ хувь 10.3% болж өссөн (Азийн хөгжлийн сан, 2025). Мөн PISA-2022 олон улсын үнэлгээнд Монгол сурагчдын үзүүлсэн амжилт, ялангуяа уншиж ойлгох чадвар сул байгаа нь СӨБ-н сургалтын чанартай өндөр хамааралтай байна (Боловсролын яам, 2025а) гэж үзсэн. Иймээс СӨБ-н багшийн үүрэг хариуцлага улам нэмэгдэж байна. Энэхүү судалгааны зорилго нь сургуулийн өмнөх боловсролын багш нарын ном уншиж өгөх арга буюу чанга уншлагын талаарх ойлголт, төлөвлөлт, хэрэгжилтийн онцлогийг судлахад оршино. Судалгаанд чанарын судалгааны арга зүйг ашиглаж, ярилцлага болон баримт бичгийн шинжилгээний аргаар мэдээлэл цуглуулсан. Судалгаанд

нийт 6 цэцэрлэгийн 12 багш оролцож, багш бүртэй ганцаарчилсан ярилцлага хийж, мөн 14 хоногийн сургалт, үйл ажиллагааны төлөвлөгөөг судалсан. Судалгааны үр дүнгээс харахад багш нар чанга уншлагыг хүүхдийн хэл яриа, ойлголт, оролцоог дэмжих арга хэмээн ерөнхийд нь ойлгож байгаа боловч түүнийг төлөвлөх, хэрэгжүүлэх арга барил багш бүрд харилцан адилгүй байна. Мөн интерактив чанга уншлагын арга нь хүүхдийн идэвхтэй оролцоо, харилцаа болон танин мэдэхүйн хөгжлийг дэмжиж байгааг илрүүлсэн. Судалгаанд оролцсон багш нар чанга уншлагыг зохион байгуулахыг хичээдэг боловч ном, хэрэглэгдэхүүний хүртээмж болон арга зүйн ойлголтын ялгаанаас шалтгаалан уг үйл ажиллагааг тогтмол, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгааг илрүүлсэн. Иймээс чанга уншлагыг Л.С.Выготскийн нийгэм-соёлын онолын үзэл баримтлалтай уялдуулан онолын үндэслэлтэйгээр төлөвлөж, шаардлагатай хэрэглэгдэхүүнээр ханган, арга зүйн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх нь сургуулийн өмнөх боловсролын сургалтын үр нөлөөг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж дүгнэж байна. Энэ нь СӨБ-н хөтөлбөрийн хэрэгжилт багшийн мэргэжлийн ур чадвар, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжээс ихээхэн хамаардаг (Боловсролын хүрээлэн, 2020) гэсэн судалгааны үр дүнтэй нийцэж байна.

Түлхүүр үг: чанга уншлага, интерактив чанга уншлага, сургуулийн өмнөх боловсрол, багшийн үүрэг, уншиж ойлгох чадвар

Удирдсан: С.Батдулам, МУБИС

Examining Student Engagement in Vocational English Classrooms: Evidence from Higher Vocational Colleges in Inner Mongolia, China

Wudanmuqier

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол Судлалын Сургууль,
Боловсрол Судлалын Тэнхим
wudanmuqier@gmail.com

Abstract. Student engagement is widely recognized as a key factor influencing learning effectiveness in English as a Foreign Language (EFL) contexts. However, traditional teacher-centered pedagogy remains dominant in vocational English classrooms, which may limit students' participation. This study surveyed students from two higher vocational colleges in Inner Mongolia. A total of 1,038 questionnaires were distributed, and 1,019 valid responses were obtained. Descriptive statistics, correlation analysis, and regression analysis were employed to examine the data. The results indicate that overall student engagement is relatively low. Affective engagement ($M = 3.208$), behavioral engagement ($M = 3.085$), and cognitive engagement ($M = 2.862$) are all below the theoretical average level (3.5), with cognitive engagement being the lowest. Correlation analysis shows that traditional teaching is significantly negatively related to student engagement ($r \approx -0.47$, $p < .01$). Regression analysis further indicates that traditional teaching has a significant negative predictive effect on all dimensions of engagement ($\beta \approx -0.47$, $R^2 \approx 0.22$). The findings suggest that student engagement in vocational English classrooms remains at a relatively low level, and traditional teaching practices are significantly negatively associated with student engagement.

Keywords: student engagement; vocational English education; higher vocational colleges; classroom participation; learner-centered reform

Удирдсан: Р.Намжилдагва, МУБИС

Сургалтын хэрэглэгдэхүүний судалгаа, зохион бүтээлт, туршилтын үр дүн

Б.Энхмандах

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Дүрслэх урлаг, технологийн сургууль, Технологийн тэнхим
enkhmandakhbat@gmail.com

Хураангуй. Боловсролын бодлогоороо тэргүүлэгч гадаадын зарим улсын хэмжээнд сургалтын практик зардал болон хэрэглэгдэхүүний зардлыг бодлогын түвшинд олон хувилбарт аргуудаар шийдвэрлэдэг байна. Тэдний санхүүжилтийн хэлбэр, давуу талуудыг харьцуулан судаллаа. Монгол улсын хувьд сургалтын хэрэглэгдэхүүний зардал, материаллаг орчныг хэрхэн шийдвэрлэж ирснийг Ерөнхий боловсролын сургуулийн дизайн технологийн хичээлийн жишээн дээр авч үзлээ. Дизайн технологийн хичээлийн багаж хэрэгсэл сургуулиудаар харьцангуй хүрэлцээтэй байдаг ч харин тухайн хичээлийг саадгүй явуулахад чухал нөлөөтэй зүйл нь материал ба сургалтын хэрэглэгдэхүүн байдаг. Эл асуудлыг ажиллаж буй сургуулийн хүрээнд туршилт ба хяналтын анги үүсгэн тандан судалж өнөөгийн байдлыг тодорхойлон дүгнэлт хийж шийдвэрлэх боломжийг хайсан туршилт, төслийн ажлыг хэрэгжүүлэн дүгнэлт гаргав. Сургалтын хөтөлбөрийг хуваарийн дагуу чанартай хэрэгжүүлэхийн тулд материал хэрэглэгдэхүүнийг өөрийн болон сургуулийн нөөц боломжид тулгуурлаж бэлтгэн суралцагч бүрд хүртээмжтэй боловсруулж, хэрэгжүүлж буй арга туршлагаа бусад багш нарт хүргэхийг зорилоо.

Түлхүүр үг: Хэрэглэгдэхүүн 1, дизайн технологийн хичээл 2, туршилт 3
Удирдсан: Д.Сэрээтэрдорж, МУБИС

Өөрийн зохицуулалттай суралцахуйг дэмжих нь

Д.Аззаяа

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Боловсрол судлалын сургууль, Боловсрол судлалын тэнхим
azzayadawaanyam@gmail.com

Хураангуй. Сурагчдын өөрийн зохицуулалттай суралцахуй нь бие даан, идэвхтэй суралцах чадварыг хөгжүүлэх чухал үндэс юм. Энэхүү судалгаанд Winne & Hadwin-ийн онолд тулгуурлан цахим даалгаварт суурилсан, дэмжлэг бүхий арга зүйг туршин хэрэгжүүлж, суралцагчдын ӨЗС чадварт үзүүлэх нөлөөг тодорхойлсон. Мөн даалгаврын гүйцэтгэлийн түвшин, хүндрэлийн зэргийг тооцсон. Судалгаанд А аймгийн ЕБС-ийн XII-р ангийн 111 сурагч хамрагдаж, биологийн хичээлийн хүрээнд (хэрэгцээ тодорхойлох, төлөвлөх, гүйцэтгэх, үнэлэх чадварыг) дэмжих цахим даалгавар гүйцэтгэсэн. ӨЗС-г 12 үзүүлэлт бүхий асуулгаар үнэлж, туршилтын өмнө ба дараах хэмжилтийг харьцуулсан. Үр дүнгээс харахад суралцагчдын ӨЗС-н нийт оноо 50.4-өөс 55.2 болж өссөн бөгөөд нийтдээ 8 оноогоор ахиц гарсан. Мөн даалгаврын гүйцэтгэлийн чанар, өөрийгөө хянах, төлөвлөх, үнэлэх чадварууд мэдэгдэхүйц сайжирсан. Ялангуяа асуудал шийдвэрлэх, бие даан суралцах чадвар илүү өндөр өсөлттэй байв. Өөрөөр хэлбэл цахим даалгаварт суурилсан үе шаттай дэмжлэг бүхий арга зүй нь суралцагчдын өөрийн зохицуулалттай суралцах чадварыг хөгжүүлэхэд үр дүнтэй болохыг судалгааны үр дүн харууллаа.

Түлхүүр үг: Өөрийн зохицуулалттай суралцахуй, цахим даалгавар, хэрэгцээ тодорхойлох, төлөвлөх, гүйцэтгэх, үнэлэх
Удирдсан: Г.Баярмаа МУБИС

**Проект дүрслэлийн даалгавар гүйцэтгэхэд оюутанд үүсэж буй хүндрэл
бэрхшээл, чанарын судалгааны үр дүн**
(ШУТИС-ийн техникийн зурагзүй хичээлийн жишээн дээр)

Д.Төгсжаргал, Э.Сувд

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Боловсрол судлалын сургууль, Боловсрол судлалын тэнхим
tugsjargal.d@must.edu.mn

Хураангуй. Техникийн зурагзүй хичээлийн “Проект дүрслэл” сэдвийн хүрээнд I-VIII долоо хоногийн хугацаанд гүйцэтгэсэн 4 даалгаврын явцад оюутнуудад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг чанарын судалгааны аргаар судалж, үр дүнг нэгтгэн танилцуулсан. Судалгаанд ажиглалт, ярилцлагын аргыг ашиглан тэмдэглэл хөтлөхийн зэрэгцээ Google Forms-оор нээлттэй асуулттай асуумж авч, оюутнуудаас дэлгэрэнгүй хариулт цуглуулсан. Цуглуулсан өгөгдлийг утгаар нь ангилж кодлох замаар шинжилж, даалгавар бүрт нийтлэг давтагдсан хүндрэлүүдийг тодорхойлсон бөгөөд үүнд 3 проекцоор төсөөлөх, SolidWorks программ ашиглах, зүсэлтийн шугам болон эхлэл цэгийг зөв тодорхойлох, стандарт баримтлалыг мөрдөх зэрэг асуудлууд зонхилж байв.

Түлхүүр үг: Проект дүрслэл, даалгаварын хүндрэл, сэдэвчилсэн шинжилгээ, чанарын судалгаа
Удирдсан: Э.Сувд, ШУТИС

Эмчилгээний тоног төхөөрөмжид техник үйлчилгээ хийх ур чадварыг үнэлсэн байдал
/Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын техникч хөтөлбөрийн III дамжаа/

Э.Энх-Үрэл

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Боловсрол судлалын сургууль, Боловсрол судлалын тэнхим
enkhurel@mnums.edu.mn

Хураангуй. Эмчилгээний тоног төхөөрөмжид өгөгдсөн параметр утга, ажлын горим, алдаа гэмтэл нь хүний эрүүл мэндэд шууд нөлөө үзүүлж, амь насыг ч хохироох эрсдэл хамгийн тоног төхөөрөмж байдаг. Иймээс уг судалгаа нь эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын техникч мэргэжлээр суралцаж буй оюутнуудын онолын мэдлэгийг эмнэлгийн бодит орчин дахь дадлага туршлагатай холбох, тэднийг ажлын байрны шаардлагад нийцүүлэн бэлтгэх асуудлыг авч үзсэн болно. Судалгааны хүрээнд чадамжид суурилсан боловсрол болон Ситуацид суурилсан суралцахуйн онолуудад тулгуурлан сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулж, эмчилгээний тоног төхөөрөмжийн хичээлийг эмнэлгийн бодит орчинд зохион байгуулснаар оюутны ур чадварыг өртөөчилсөн шалгалтаар үнэлэх загварыг боловсруулсан. Судалгааны үр дүнд сургалтын хөтөлбөрийн сайжруулалт нь төгсөгчдийн ажлын байран дээрх өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, ажил олгогчдын сэтгэл ханамжид эергээр нөлөөлөх боломжтойг харууллаа.

Түлхүүр үг: Гардан үйлдэл, Эмнэлзүйн бодит орчин

ЕБС-ийн 5 дугаар ангийн англи хэлний сурах бичгийн соёлын агуулгын шинжилгээ

У.Дэлгэрсайхан

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Боловсрол Судлалын сургууль, Боловсрол Судлал Арга зүйн тэнхим
dniceyesun@gmail.com

Хураангуй. Энэхүү судалгааны зорилго нь ерөнхий боловсролын сургуулийн V ангийн англи хэлний Pearson хөтөлбөрийн *Wider World Starter* сурах бичиг дэх соёлын агуулгыг тодорхойлон шинжлэхэд оршино. Судалгаанд баримт бичгийн шинжилгээ болон хагас бүтэцлэгдсэн ярилцлагын аргыг хослуулан ашигласан. Баримт бичгийн шинжилгээгээр сурах бичгийн бичвэр, зураг дахь соёлын элементүүдийг Chao (2011, 2014)-ийн соёлын ангиллын загвар (Source culture буюу үндэсний соёл (SC), Target culture буюу англи эх хэлтэн орнуудын соёл (TC), International culture буюу олон улсын соёл (UC), Intercultural interaction буюу соёл хоорондын харилцаа (ICI), Universality across cultures буюу соёлын нийтлэг шинж (UC))-ын дагуу ангилан кодож, давтамжийг тооцоолсон. Мөн тус сурах бичгийг ашиглаж буй ЕБС-ийн 12 англи хэлний багштай ярилцлага хийж, соёлын агуулгын талаарх тэдний үзэл бодлыг тодруулсан. Судалгааны үр дүнгээс харахад сурах бичигт соёлын агуулга харьцангуй өргөн хүрээнд туссан боловч түүний тархалт жигд бус байна. Тодруулбал, соёлын нийтлэг шинж (UC) хамгийн өндөр давтамжтай (159), дараа нь англи эх хэлтэн орнуудын соёл (TC) (119) зонхилж байгаа бол олон улсын соёл (IC) (30), соёл хоорондын харилцаа (ICI) (19), үндэсний соёл (SC) (20) харьцангуй бага туссан байна. Ярилцлагын үр дүн нь эдгээр дүгнэлтийг бататгаж, багш нарын дийлэнх нь сурах бичигт соёлын агуулга хангалттай боловч төрөл, тэнцвэрийн хувьд жигд бус байгааг онцолсон. Ялангуяа Монголын үндэсний соёлын агуулгыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзсэн. Иймд англи хэлний сурах бичигт соёлын агуулгыг илүү тэнцвэртэй тусгах, ялангуяа үндэсний болон олон улсын соёлын төлөөллийг нэмэгдүүлэх, соёл хоорондын харилцааг илэрхийлсэн агуулгыг өргөжүүлэх шаардлагатай гэж дүгнэв.

Түлхүүр үг: Соёлын агуулга, англи хэлний сурах бичиг, соёлын ангилал
Удирдагч: С.Батдулам, МУБИС

Сурагчид "Хиймэл оюун"-ыг хэрэглэж буй байдалд хийсэн шинжилгээ (Суурь боловсролын жишээн дээр)

Отгонбаяр Наранцацрал

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Боловсрол Судлалын сургууль, Боловсрол Судлал Арга зүйн тэнхим
OtgonbayrNarantsatsral@gmail.com

Хураангуй. Хиймэл оюуны технологи нь боловсролын салбарт агуулга боловсруулах, суралцах үйл явцыг дэмжих, сургалтыг хувь хүнд тохируулах, үнэлгээний үйл ажиллагааг автоматжуулах зэрэг олон чиглэлээр ашиглагдаж эхэлсэн. Ялангуяа сүүлийн жилүүдэд үүсгэгч хиймэл оюун буюу Generative AI эрчимтэй хөгжсөнөөр боловсролын орчин дахь хиймэл оюуны хэрэглээ шинэ шатанд гарсан байна. Ийм нөхцөлд сурагчдын хиймэл оюуны хэрэглээний бодит байдал, түүний бодит хэрэглээг судлах шаардлага үүсэж байна. Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын өсвөр насны сурагчдын хиймэл оюуны хэрэглээний түвшин, ашиглах зорилго, ойлголт, хэрэглээний онцлогийг тодорхойлон шинжилж, зохистой ашиглах чиглэлээр санал боловсруулахад оршино. Судалгаанд асуулгын аргыг

ашиглан Улаанбаатар хотын Нийслэлийн Ерөнхий боловсролын 163 дугаар сургуулийн 7-9 дүгээр ангийн 164 сурагчдаас тандалт судалгаа авч, судалгааны бодит нөхцөлийг баталгаажуулсан. Үүний дараа үндсэн судалгааг тус сургуулийн нийт 217 сурагчаас Google Forms платформ ашиглан цахим хэлбэрээр цуглуулж SPSS программ ашиглан боловсруулав. Мөн судалгааны үр дүнг гүнзгийрүүлэн тодруулах зорилгоор ярилцлагын аргыг ашиглаж, чанарын мэдээлэл цуглуулж сэдэвчилсэн шинжилгээгээр боловсруулав. Судалгааны үр дүнгээс харахад оролцогч сурагчдын дийлэнх буюу 84.0% нь хиймэл оюуныг ашиглаж байсан нь уг технологийн хэрэглээ өсвөр насныхны дунд өргөн тархсаныг харуулж байна. Мөн анги ахих тусам хиймэл оюуны хэрэглээ нэмэгдэх хандлага ажиглагдсан. Хиймэл оюуныг ашиглах үндсэн зорилго нь “өөрийн сонирхсон зүйлсийн талаар асуухын тулд ашигладаг” гэсэн үзүүлэлтэд 141 (65.0%) сурагч “тийм”, 37 (17.1%) сурагч “маш их тийм” гэж хариулсан байгаагаас харахад сурагчид хиймэл оюуныг суралцах үйл ажиллагаанаас гадна өөрийн сонирхол, хэрэгцээнд тулгуурлан бие даан мэдлэг олж авахад ашиглаж байгааг харуулж байна. Энэ нь сурагчдын идэвхтэй, бие даан суралцах хандлага нэмэгдэж байгааг илтгэх эерэг үзүүлэлт юм. Түүнчлэн ChatGPT зэрэг хиймэл оюуны хэрэгслүүдийг бусад төрлөөс илүү өргөн ашиглаж байгаа нь ажиглагдсан. Иймд сурагчдын хиймэл оюуны хэрэглээ бодитоор оршин байгаа боловч түүнийг илүү үр дүнтэй, зохистой ашиглахын тулд боловсролын орчинд чиглэсэн хэрэглээний заавар, сургалтын арга зүй, зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна. Энэхүү судалгааны үр дүн нь өсвөр насныхны хиймэл оюуны хэрэглээг оновчтой чиглүүлэхэд практик ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: “AI in education”, “AI Usage” “Generative AI” “ChatGPT use in learning”

Удирдсан: Н.Мөнхцэцэг, МУБИС

Монгол оюутнуудад хятад хэлээр бичих явцад тохиолдож буй түгээмэл бэрхшээлийг судалсан нь

Т.Энэбиш

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Боловсрол судлалын сургууль, Боловсрол судлалын тэнхим
t.enebish999@gmail.com

Хураангуй. Энэхүү судалгаа нь монгол оюутнуудын хятад хэлээр бичих явцад тохиолдож буй бэрхшээлийг илрүүлж тодруулах зорилготой. МУИС, МУБИС, ШУТИС, СЭЗИС, МУИС-ийн Зүүн бүсийн сургууль, МУИС-ийн Баруун бүсийн сургуулиудад хятад хэл сурч буй 400 оюутнаас тоон болон чанарын судалгааны аргыг ашиглан 5 шалгуур үзүүлэлтээр асуулга, ярилцлага, эх материалд дүн шинжилгээ хийх аргыг ашиглан судалсан. Судалгаагаар оюутнуудын 74.9% нь ханзны зурлага, түлхүүр үсэг, хажуу тал, бүтэц зэргийг сайн эзэмшээгүй, нээлттэй асуулгаар 72.75% нь ханз үсэг бичих хамгийн хэцүү гэсэн, 52% нь хэл зүйн дүрэм бэрхшээлтэй, 48% нь үгийн сан багатай, 51% нь найруулгын алдаа их гаргадаг, бичвэрийн уялдаа холбоо, логик дарааллыг алддаг гэж хариулснаас суралцагчдад хятад хэлээр бичихэд нэлээд бэрхшээл байгаа нь харагдаж байна. Судалгааны үр дүнд суралцагчдад хятад хэлээр бичихэд тохиолдож буй бэрхшээлд ангилал хийсэн бөгөөд улмаар хятад хэлээр бичих чадвар нь ханзын бүтэц, хэл зүйн мэдлэг, найруулга зүй, танин мэдэхүйн үйл явц зэрэг олон хүчин зүйлсээс хамаардаг. Иймээс бичих чадварыг хөгжүүлэх сургалт нь зөвхөн бичгийн дүрэм заахаас гадна үйл явцад суурилсан бичих арга зүй, зураглал, хамтран сурах, төлөвлөх, засварлах шатлалт үйл ажиллагааг багтаасан цогц арга зүйтэй байх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Түлхүүр үг: Хэлзүйн алдаа, үгийн сан, бичих чадвар, ханз үсэг, HSK шалгалт

Удирдсан: Г.Цогзолмаа, МУБИС

Химийн туршилтад суурилсан сургалтыг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудал

У.Нарантуяа¹ Б.Отгонжаргал²

¹УБИС, Боловсрол судлалын сургууль, Боловсрол судлалын тэнхим

²Техник Технологийн Их Сургууль

Ukhnanarantuya9@gmail.com

Хураангуй. Хими нь онол, туршилтын шинжлэх ухаан бөгөөд ЕБС-ийн хими сургалтаар сурагчдад шинжлэх ухаанч арга барилыг төлөвшүүлэх зорилт чухал байр суурийг эзэлдэг. Туршилтад хичээл зохион байгуулах нь суралцагчдын идэвхтэй оролцоо, хамтын ажиллагааг бий болгохын зэрэгцээ онолын мэдлэгийг практикт ашиглах боломжийг олгодог. Иймээс хими сургалтын хэрэгжилтийн явцыг хянах зорилгоор Улаанбаатар болон орон нутгийн багш нараас асуулгын судалгаагаар багш нарын туршилт төлөвлөн хийх хэлбэр, тулгамдаж буй асуудал зэргийг судалсан. Судалгааны өгөгдлийг SPSS программд оруулан боловсруулж, тоон болон чанарын шинжилгээ хийсэн. Мөн судалгааны асуулгын найдвартай байдлыг Cronbach's alpha коэффициентээр үнэлж, хувьсагчдын хоорондын хамаарлыг cross tabulation аргаар тодорхойлон үр дүнг гаргалаа. Багш нар туршилтад хичээл төлөвлөн зохион байгуулах нь байршлаас үл хамаарч байгаа. Харин лабораторийн хүрэлцээ, суралцагчдын тоо, багшийн ачаалал зэрэг бэрхшээл тулгарч байсан учир ихэвчлэн видео үзүүлэх, багш өөрөө үзүүлэх туршилт хийдэг гэсэн үр дүнд хүрлээ. Энэ нь хими туршилтад суурилсан сургалтын хэрэгжилт хангалтгүй байгаа нь харагдаж байна.

Түлхүүр үг: Хими сургалт, туршилтад суурилсан сургалт, практик ур чадвар

Хос хэлний боловсролын онолын хүрээ: АХИС-г сургалтад хэрэгжүүлэх нь

Э.Оюунчимэг

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Боловсрол судлалын сургууль, Боловсрол судлалын тэнхим
oyunchimeg.en@gmail.com

Хураангуй. Энэхүү онолын өгүүллээр хос хэлний суралцахуйн нэгэн түгээмэл арга хандлага болох Агуулга болон хэлийг интеграцчилсан суралцахуй (АХИС)-н онолын үндэслэлийг судаллаа. Сургалтын цагийг нэмэгдүүлэхгүйгээр хэлийг агуулгад интеграцчилж ашиглах, агуулгыг хоёрдогч хэлээр эзэмшүүлдэг энэхүү арга хандлага нь суралцахуйн ерөнхий онол болон хоёрдогч хэлний суралцахуйн онол аль алинд нь суурилсан байна. Өгүүллийн эхэнд АХИС-н арга хандлагын үндсэн хүрээ болох 4С загварт суурилан тайлбарласан. Улмаар суралцахуйн ерөнхий онолоос нийгмийн конструктив онолд үндэслэн тодорхойлж, танин мэдэхүйн давхар ачааллын онолыг судлан АХИС-н хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах үндэслэлийг тусгалаа. Хоёрдогч хэл суралцахуйн онолын төлөөллөөр Оролтын онол, Тэнцвэртэй бус санах ойн онолыг авч үзсэн бөгөөд төгсгөлд нь цаашдын хос хэлний судалгааны суурь болгон ашиглаж болох загварыг боловсруулж онолын таамаглал дэвшүүллээ. Танин мэдэхүйн ачааллын онол, Тэнцвэртэй бус санах ойн онолд үндэслэн хос хэлээр суралцаж буй сурагчийн танин мэдэхүйн ачаалал өндөр байдаг нь агуулгыг гүн гүнзгий ойлгох, тогтооход давуу тал болох магадлалтай гэж үзэх үндэслэл байна. Нийгмийн конструктив онолыг баримтлан хос хэлээр суралцаж буй сурагчийн хэлний идэвхтэй хэрэглээг дэмжих ба үүнд Ойрын бүсийн хөгжлийн онолын дагуу багшийн үүрэг, чиглүүлэг онцгой ач холбогдолтой байна. Хос хэлний боловсролын онолын үндэслэлийг нэгтгэн судалснаар цаашид эмпирик судалгаанд ашиглах, нарийвчлан судлахад суурь болох ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: Хос хэлний боловсрол, хос хэлний онол, агуулга болон хэлийг интеграцчилсан суралцахуй

Монгол хөөмийн уламжлалт заах арга зүйн онцлог ба ганцаарчилсан сургалт

Е.Sachaoriga, Э.Дүүриймаа

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,
Боловсрол судлалын тэнхим
sachaoriga@gmail.com

Хураангуй. Монгол хөөмийн урлагийн онцлог нь хүн өөрөө өөртэйгөө ажиллах арга, хүнээс байгальд, хүнээс мал ахуй, амьтад руу хандсан хандлагаар үүсэн бүрэлдсэн нь ганцаарчилсан төрөл хэлбэрийн шинжийг өөртөө агуулсан болох нь харагдаж байна. Тэрхүү анхдагч чанар нь уламжлалт заах арга зүйд чухал тусгалаа олж хөгжжээ. Тиймээс хувь хүний онцлог, мөн чанарт тохирсон дасгал сургуулилтыг байгаль, ахуйтай харилцах арга замаар хөгжүүлж, амьсгалын техникийг эзэмшүүлж ирсэн нь монгол хөөмийн заах арга зүйн уламжлалт хэлбэр нь ганцаарчилсан арга зүйн онцлогтой болохыг тус өгүүлэлд авч үзэв. Монгол хөөмийг шавь сургалтын аргаар заан сургаж ирсэн ахмад хөөмийчдийн арга туршлага, ганцаарчилсан болон хувьчилсан сургалт (personalized learning), суралцагч төвтэй сургалтын талаар эрдэмтдийн дэвшүүлсэн санал, дүгнэлтүүдийг харьцуулах, нэгтгэн дүгнэх зэрэг судалгааны арга, аргачлалуудыг гол болгов. Монгол хөөмийн сургалт нь багш, шавийн шууд харилцаанд тулгуурласан, аман уламжлалаар (Live heritage) дамждаг өвөрмөц арга зүйтэй юм. Түүнчлэн монгол хөөмийн уламжлалт заах арга зүй нь танхим дүүрэн хүүхэдтэй ажиллахдаа гол бус харин ганцаарчилсан болон 4-5 хүүхэдтэйгээр хичээлийн үндсэн дасгалуудыг орж, тодорхой практик дасгалуудыг олноор буюу 10 болон түүнээс дээш хүүхдүүдэд заан сургадаг туршлагууд бий. Хөөмийгөөр хөөмийлж, эсвэл заан сургаж ирсэн арга туршлагыг үзэхэд ихэнхдээ монголчууд байгаль дээр ганцаар, эсвэл мал ахуйгаа хариулан байх цаг үеүүддээ ганцаарчилсан арга, хэлбэрээр хөгжүүлж, байгалийн дуу чимээ болох гол усны хоржигноон, хад хясаан дуу чимээ, салхины исгэрээ, мал, амьтдын дуу чимээ зэргийг дуурайн баяжуулж ирсэн түүхтэй байна. Хөөмийн шавь сургалтын арга хэлбэр ч мөн ялгаагүй суралцагч хүнийг танин шинжиж, түүний өгөгдөл, хувийн чадамж, хүлээж авах чадвар гэх мэт нас, бие, сэтгэхүй онцлогт тохирсон анхан түвшнээс ахисан түвшний дасгал, сургуулилт хийж ирсэн уламжлалт туршлагууд байна. Үүнийг өнөөгийн танхимын сургалтын хөтөлбөрт тусган хичээллүүлж байгаа нь уламжлалт сургалтын үр нөлөө билээ. Хөөмий нь дуулах, ярихтай адилгүй амьсгал, шахааны тусламжтайгаар илэрхийлэн гаргадаг ихээхэн хүчийг хүний биеэс шаарддаг. Тиймээс хөөмийг заан сургах нь нэлээд хэцүү бөгөөд урт хугацаатайгаар аажим аажмаар дасгалжуулж хүний биед дадуулдаг онцлогтой байна.

Түлхүүр үг: Хөөмийн урлаг, уламжлалт сургалт, хүн, байгаль, мал ахуй, соёл
Удирдсан: Д.Мөнхжаргал, МУБИС, Э.Дүүриймаа, СУИС

Сагсан бөмбөгийн дасгалжуулагчийн манлайлал оюутан тамирчдын сэдэл ба багийн уур амьсгалд хамаарах нь

С.Нуржан, Б.Бат-Отгон

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Биеийн таамирын сургууль, Спорт тоглоомын тэнхим
nurjan@msue.edu.mn

Хураангуй. Энэхүү судалгааны зорилго нь оюутны сагсан бөмбөгийн багийн дасгалжуулагчийн манлайлал нь тамирчдын сэдэл болон багийн уур амьсгалд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлоход оршино. Олон улсад батлагдсан шкалуудыг үндэслэн боловсруулсан 22 асуулт бүхий асуулгыг оюутны

лигийн сагсан бөмбөгийн тамирчдын дунд нээлттэй түгээж, дөрвөн багийн 48 тамирчин сайн дурын үндсэн дээр оролцсон. Өгөгдөл цуглуулахдаа 5 шатлалт Likert хэмжүүртэй стандартчилсан асуулга хэрэглэсэн. Хэмжилтийн найдвартай байдлыг Cronbach's Alpha коэффициентоор үнэлэхэд дасгалжуулагчийн манлайллын хэв маяг ($\alpha = 0.93$), тамирчны сэдэл ($\alpha = 0.77$), багийн уур амьсгал ($\alpha = 0.93$) гэж гарсан нь хэмжүүрүүдийн дотоод нийцтэй байдал хангалттай өндөр байгааг илтгэнэ. Статистик шинжилгээний үр дүнгээс харахад дасгалжуулагчийн манлайлал нь тамирчдын сэдэл болон багийн уур амьсгалд эерэг, статистикийн хувьд ач холбогдолтой хамааралтай байна. Ялангуяа дэмжигч болон чөлөөт манлайллын хэв маяг нь тамирчдын бэлтгэл сургуулилтад оролцох идэвх, өөрийгөө хөгжүүлэх хүсэл болон багийн хамтын ажиллагааг нэмэгдүүлж, илүү эерэг уур амьсгал бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлж байв. Харин захирангуй манлайллын хэв маяг нь сэдэл болон багийн уур амьсгалд сулруулсан буюу сөрөг хандлагатай байв. Судалгаа нь Монголын оюутны сагсан бөмбөгийн орчинд дасгалжуулагчийн манлайллын хэв маяг, тамирчдын сэдэл болон багийн уур амьсгалын харилцан хамаарлыг нэг загварт тоон аргаар зэрэг судалсан нь шинэлэг юм. Судалгааг дасгалжуулагчийн дэмжигч, чөлөөт манлайллын хэв маяг нь тамирчдын сэтгэл зүйн байдал, багийн уур амьсгал болон спортын гүйцэтгэлийг сайжруулахад чухал үүрэгтэй болох нь батлагдлаа.

Түлхүүр үг: Манлайлал, тамирчид, сагсан бөмбөг, багийн нэгдэл
Удирдсан: Б.Бат-Отгон, МУБИС

Чеховын «Дугтуйтай хүн» болон Лу Синьгийн «А Кюгийн түүх»-ийг харьцуулан судлах

Dalaima

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Нийгэм, Хүмүүнлэгийн ухааны сургууль, Утга зохиолын тэнхим
3697183799@qq.com

Хураангуй. Антон Чеховын «Дугтуйтай хүн» болон Лу Шюний «А Кюгийн үнэн түүх» нь 19-р зууны Оросын шүүмжлэлт реализм болон 20-р зууны Хятадын орчин үеийн уран зохиолын түүхэн бүтээлүүд юм. Хоёр зохиолч өөр өөр соёлын нөхцөл байдал, нийгмийн өөрчлөлтийн үед амьдарч байсан ч хоёулаа гажуудсан нийгэм дэх "Эмгэг судлалын хувь хүн"-д анхаарлаа төвлөрүүлж, Беликов, А Кью нарын сонгодог дүрүүдийг бүтээх замаар феодалын автократизмын хүн төрөлхтнийг дарангуйлж, гажуудуулж байгааг гүнзгий илчилсэн. Энэхүү нийтлэлд хоёр бүтээлийг бүтээлч байдал, дүрийн дүрслэл, оюун санааны хүнд хэцүү байдлын үндэс, үзэл суртлын гэгээрлийн утга агуулга, бодитой илчлэлт зэрэг олон хэмжээсээр системтэйгээр харьцуулсан болно. Энэ нь үндэсний зан чанарын шүүмжлэл дэх нийтлэг болон ялгаатай талуудыг шинжлэх, энгийн хүмүүсийн эмгэнэлт явдлын цаад түүхэн хувь тавиланг илчлэх, хүн төрөлхтнийг сэрээх, нийгмийн дэвшлийн төлөөх сонгодог уран зохиолын мөнхийн дуудлагыг тодруулах зорилготой.

Түлхүүр үг: Дугтуйтайхүн, А Кюгийн үнэн түүх, дүрүүдийн харьцуулалт, үндэсний шинж чанарын шүүмжлэл

Удирдсан: С.Хөвсгөл, МУБИС

**“Эрдэнийн сан Субашид”-д тогтвортой байдлын цогц чадамж тусгагдсан
байдалд хийсэн судалгааны дүн**

Gegentana

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,
Боловсрол судлал арга зүйн тэнхим
g976254904@163.com

Хураангуй. Нийгмийн хөгжилт, цаг үеийн өөрчлөлтийг дагалдан, ойрын жилүүдээс ирээдүйн боловсролын агуулгад тогтвортой хөгжил, тогтвортой хөгжлийн боловсрол, тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол зэрэг үзэл санаа, онолууд илүү яригдаж, боловсролын салбарын шинэ зуунд хүн хүмүүжүүлэх хандлага чиглэлийг илэрхийлж байна. Эдгээр шинэхэн онол ойлголтуудыг ирээдүйн залуу нэг үеийн хүмүүжил төлөвшилд хэрэглэхэд өвөг дээдсээс уламжилж ирсэн уламжлалт соёлын агуулга, үзэл санаатай уялдуулж боловсролын салбарын үйл ажиллагааг нэн үр бүтэмжтэй чанартай явагдуулах шаардлага тавигдана. Энэ өгүүлэлд арван гуравдугаар зууны үеэр зохиогдсон уран зохиолын охь шүлт болох сургаал шүлэг “Эрдэнийн сан Субашид”-д тогтвортой байдлын цогц чадамжийн агуулга хэр тусгагдсан байдлыг 8 багц 26 шалгуураар харилцан агуулгын уялдаа холбоотой байх, үүний дотроо нягт уялдаа холбоотой ба уялдаа холбоо сул байх, хоорондоо уялдаа холбоо байгаагүй гэж ялган тодруулахдаа эх зохиол судлах аргыг хэрэглэсэн. Шинжилгээний үр дүнг эх зохиол “Эрдэнийн сан Субашид”-ын бүтцэд суурилж 9 бүлэгт ангилж боловсруулжээ. Харьцуулан шалгасны дүнд, “Эрдэнийн сан Субашид”-ын 458 бадаг шүлгээс 447 бадаг нь тогтвортой байдлын түлхүүр 8 цогц чадамжтай агуулгын уялдаа холбоотой байжээ. Үүний дотроо 428 бадаг нь нягт уялдаа

холбоотой, 19 бадаг нь уялдаа холбоо сул байв. 11 бадаг шүлэгтэй нь хоорондоо уялдаа холбоогүй байжээ.

Түлхүүр үг: Шинэ онол, уламжлалт соёл, харьцуулал
Удирдсан: Ч.Байгалмаа, МУБИС

"Өнөөдөр" сонины эрүүл мэндийн мэдээллийн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам

Байгаль

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Нийгэм, Хүмүүнлэгийн ухааны сургууль, Утга зохиолын тэнхим, Сэтгүүл зүйн тэнхим
hul330743005@gmail.com

Хураангуй. Энэхүү өгүүлэлд Монголын өдөр тутмын хэвлэл болох “Өнөөдөр” сонины 2014-2023 оны эрүүл мэндийн сэдэвт нийтлэлүүдийг чанарын контент шинжилгээний аргаар судалж, мэдээллийн чанар, ёс зүй, хүртээмжийн хүрээнд тулгарч буй асуудлуудыг тодорхойлов. Судалгааны үр дүнд эх сурвалжийн тодорхой бус байдал, баримт шалгалтын сул тогтолцоо, ёс зүй, нууцлалын зөрчил, сенсацчилсан хандлага, мэдээллийн зөрчил ба шинэчлэлийн асуудал, хүртээмж ба ойлгомжийн дутагдал зэрэг зургаан үндсэн асуудал илэрсэн. Эдгээрийг шийдвэрлэх хүрээнд баримт шалгалтын системийг бэхжүүлэх, мэргэжлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, ёс зүйн стандартыг мөрдүүлэх, хүртээмжтэй контент хөгжүүлэх зэрэг арга замыг санал болгон дэвшүүлэв.

Түлхүүр үг: Эрүүл мэндийн сэтгүүл зүй, баримт шалгалт, ёс зүй, дезинформаци, хэвлэл мэдээлэл

Жангар хийгээд Калевалагын баатрын удам гарлын домог зүйн харьцуулал

Б.Тэргэл (Terigeli)

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Нийгэм, Хүмүүнлэгийн ухааны сургууль,
Утга зохиолын тэнхим
b.tergel1123@gmail.com

Хураангуй. Энэхүү илтгэлд Монголын “Жангар” болон Финландын “Калевала” туулийн баатрын удам гарлын домог зүйн өгүүлэмжийг харьцуулан авч үзэв. Судалгаагаар эдгээр хоёр туульд баатрын үүсэл гарлыг байгалийн хүчин, ялангуяа усны эх сурвалжтай холбон тайлбарласан нийтлэг шинж ажиглагдлаа. Энэ нь хүн төрөлхтний үүслийг устай холбодог дэлхий нийтийн домог зүйн ойлголттой нийцэж байна. Харин “Жангар” туульд баатрын удам угсааг хэд хэдэн үеэр тодорхойлон өгүүлдэг бол “Калевала”-д баатрын төрөх үйл явцыг бэлгэдэлт, өвөрмөц байдлаар дүрсэлсэн ялгаатай тал илэрч байна. Ийнхүү уг илтгэл нь хоёр өөр баатарлаг туулийн баатрын үүсэл гарлын тухай ойлголтын нийтлэг болон өвөрмөц шинжийг тодруулж, тэдгээрийн домог зүйн сэтгэлгээг харьцуулан шинжлэхийг зорилоо.

Түлхүүр үг: Жангар, Калевала, баатрын удам гарал, домог зүй, харьцуулал

XX зууны дунд үеийн эрэгтэй яруу найрагчдын бүтээл дэх эм хүйсийн дүрслэлийн мэдрэмж
(Хайрын шүлгийн жишээн дээр)

М.Чинхүсэл

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль, Утга зохиолын тэнхим
Chinhusel63@gmail.com

Хураангуй. Уран зохиолын судлал шинжлэлийн харьцангуй шинэ үеийн чиглэл болох хүйсийн шинжлэлийн үүднээс монголын орчин үеийн яруу найраг дахь эрэгтэй зохиолчдын эм хүйсийг дүрслэх зүй тогтол, бүлэг цогцын хүйсийн стереотипийг шинжилж үр дүнг танилцуулна. Дэлхийн уран зохиол төдийгүй бүхий л салбар, тэр бүү хэл оршин байхуйн тухай асуудалд ч бинарын тогтолцооны хамгийн том нэгж болох эр болон эм хүйсийн маргаан мөнхөд дагалддаг нь нууц биш. Бидний дурдан буй үгийн урлагийн бичгийн уламжлал, элдэв аман яриа зэрэг, бүхий л түвшний уран зохиолын дискурсүүдэд ямагт эм хүйсийг дорд үзэх байдал ажиглагдах нь бий. Харин орчин үеийн монголын яруу найрагт энэ мэт тогтсон нийтийн үзэл ухамсар хэрхэн илэрч байсан нь анхаарал татахуйц сэдэв болж чадах юм.

Түлхүүр үг: Яруу найраг, хүйсийн шинжлэл, жендэр, дүр дүрслэл, эр хүйс, эм хүйс, бүлэг цогцын

"Ам" хэмээх концептын зүйрлэл ба төлөөллийн утгыг шинжлэх нь
(Ч.Лодойдамбын "Тунгалаг тамир" романы жишээн дээр)

Ч.Цэрэнсугар

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль, Монгол хэлний тэнхим
tseegiitseegii916@gmail.com

Хураангуй: Хэл бол тухайн үндэстний сэтгэхүйн онцлог, түүх замнал, ахуй байдал, ёс заншлын илрэл юм. Тиймээс тухайн ард түмний амьдралын туршлага, хэв маяг, зан заншил, бэлгэдэл, аливаа ухагдахууныг таньж мэдсэн туршлага, ертөнцийн үзэл, ухамсар, философи сэтгэлгээний онцлогийг хамгийн их шингээсэн хэлийг, хэлний баримтыг шинжлэн судлах шаардлагатайг танихуйн хэл шинжлэлд онцгойлж, сүүлийн жилүүдэд судалсаар байна. Монгол хэлний хүний биеийн эрхтний холбоотой үг хэллэгийг монгол хэлний уугуул үг хэмээн үздэг бөгөөд хэлний баримтад хамгийн их зүйрлэлийн болоод төлөөллийн утга илэрхийлдэг. Бид энэхүү судалгаандаа монгол хэлний "ам" хэмээх үг орсон хэлц үг болоод хэлний баримтаас танихуйн зүйрлэлийн ба төлөөллийн утгыг тодорхойлохыг гол зорилго болголоо. Ингэхдээ Ч.Лодойдамбын "Тунгалаг тамир" романы жишээн дээр тулгуурлан "ам" хэмээх концептын зүйрлэлийн ба төлөөллийн утгууд хэрхэн үүсэж буйг танихуйн хэл шинжлэлийн үүднээс авч үзэв. "Ам" хэмээх концептын зүйрлэлийн хувьд аливааг агуулдаг савтай адилтган зүйрлэх бөгөөд "аманд орох" нь саванд оруулсан утгаар илэрч, "ам алдах" нь савнаас асгарах гарах утгыг тус тус илэрхийлж байна. Үүнээс гадна "хүүдийний ам" хэллэгт "ам" эрхтний үүргийг шилжүүлэн зүйрлэж, эд юмсын хийх, нээх үүрэг бүхий шинжтэй нь холбон илэрхийлж байна. Мөн "уулын ам" хэллэгт хүний "ам"-ыг уулын хавчиг хөндийтэй хэлбэр дүрсийн зүйрлэлээр адилтган нэрлэсэн буюу "Уул бол хүн" хэмээх танин мэдэхүйн загвараар хүний биеийн эрхтнийг байгалийн үзэгдэлд шилжүүлэн илэрхийлж байна. Энэ зүйрлэлийн хувьд "тарваганы нүх шиг том ам" хэллэгт хашгирч байгаа хүний амыг тарваганы нүхтэй зүйрлэн гүн хар гэсэн дүр төрхийг бий болгосон байна. "Ам" хэмээх концептын төлөөллийн хувьд "ам бүл" хэллэгт "ам" нь хэсгээр бүхлийг төлөөлж нэг гэрт амьдарч буй хүний тоог төлөөлөн нэрлэх утга илэрхийлж байна. "Аман хүзүүнд орох" хэллэгт биеийн

эрхтний байрлалаар уралдааны хоёрдугаар байрыг төлөөлөн нэрлэж, "ам авах" хэллэгт бөхийн барилдааны үйлдлээр дааж авч барилдах зэргээр төлөөллийн утгууд илэрч байна. Судалгааны үр дүнд монгол хэлэнд "ам" хэмээх концепт нь танихуйн зүйрлэлийн хувьд, сав зүйрлэл, үүргийн зүйрлэл, хэлбэр дүрсийн зүйрлэл, ил зүйрлэл гэх мэтээр танихуйн зүйрлэл, утга илэрч, төлөөллийн аргаар ам бүл, хоёрдугаар байр гэх мэтээр өөр зүйлсийг төлөөлөн нэрлэж утгын өргөсөл үүсдэг болохыг хэлний баримтад тулгуурлан тодорхойллоо. Түүнчлэн “ам” хэмээх үг орсон хэлц хэллэгүүд нь монгол хэлний онцлог, ард түмний ахуй амьдрал, ертөнцийг үзэх үзэл, танин мэдэхүйн хэв маягийг тодорхой илтгэж байна. Иймээс “ам” концепт нь танихуйн зүйрлэл болон төлөөллийн утгын хүрээнд монгол хэлний баялаг, дүрслэх чадварыг илтгэх чухал нэгж болох нь нотлогдож байна. Ингэснээр хэл нь зөвхөн харилцааны хэрэгсэл бус, харин тухайн үндэстний сэтгэлгээ, соёлын цогц илэрхийлэл болохыг энэхүү судалгаа дахин баталж байна.

Түлхүүр үг: зүйрлэл, төлөөлөл, танихуйн утга, "ам", хэлц үг

Удирдсан: П.Эрдэнэтуяа, МУБИС